

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАГНАЛ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
5-р хороо, Самбуугийн гудамж, М Плаза
оффис 6 давхар, 607 тоот
Утас: 99117121; 89601000
И-мэйл: info@mnraudit.mn

2021-03-16 дугаар 21-01/105

Танай _____ - ны дугаар _____ -т

Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН Г

Дүгнэлт

Бид “АЛТАН ГУУ ББСБ” ХХК (“Компани” гэх)-ийн 2020 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эгтгэлүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахад төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эгтгэдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий эгтгэдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтланд бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл нийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "АЛТАН ГУУ ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2021 оны 03 дугаар сарын 16



Ч.БАТТӨМӨР
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

/мян.төг/

Үзүүлэлт	Тодотгол	2019.12.31	2020.12.31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгөн хөрөнгө	1	457,480.4	26,836.4
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/			
Зээл /цэврээр/	2	2,659,743.9	2,874,451.6
Санхүүгийн түрээсийн тооцооны авлага /цэврээр/			
Факторингийн тооцооны авлага /цэврээр/			
Бусад авлага	3	41,296.7	559,510.2
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	4	2,468.0	7,521.6
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн		3,160,989.0	3,468,319.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	5	326,722.4	239,163.2
Биет бус хөрөнгө	6	1,375.0	3,850.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		328,097.4	243,013.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,489,086.5	3,711,333.0
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр	7	200,000.0	
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг	8		2,196.2
Салбар хоорондын тооцооны өглөг			
Ногдол ашгийн өглөг			
Цалингийн өглөг			
ЭМДНДШ-ийн өглөг			
ХАОАТ-ын өглөг			1,528.0
Орлогын албан татварын өглөг		36,651.7	
Бусад	9		116,528.2
Богино хугацаат өр төлбөрийн дүн		236,651.7	120,252.4
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл		210,600.0	197,550.4
Төслийн зээлийн урт хугацаат санхүүжилт			
Урт хугацаат өр төлбөрийн дүн		447,251.7	317,802.8
НИЙТ өр төлбөрийн дүн		447,251.7	317,802.8
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Энгийн хувьцаа		2,500,000.0	2,500,000.0
Давуу эрхтэй хувьцаа			
Халаасны хувьцаа			
Хувьцаат капиталын дүн		2,500,000.0	2,500,000.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал/		541,834.8	893,530.2
Эзэмшигчдийн өмчийн дүн		3,041,834.8	3,393,530.2
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН		3,489,086.5	3,711,333.0

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

Үзүүлэлт	Тодотгол	/мян.төг/	
		2019.12.31	2020.12.31
ХҮҮГИЙН ОРЛОГО		653,156.2	1,222,696.9
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	10	801,510.5	1,564,866.7
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	10	416.9	4,427.4
Харилцах дансны хүүгийн орлого	10	93.7	81.8
Хүүгийн орлогын буцаалт		(148,864.9)	(346,678.9)
ХҮҮГИЙН ЗАРДАЛ		34,249.8	35,009.4
Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал		34,249.8	35,009.4
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал			
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО		618,906.4	1,187,687.5
ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	10	29,040.5	55,173.7
ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ		196,041.7	208,745.0
Үндсэн болон нэмэгдэл цалин		96,707.5	103,659.0
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал		12,088.4	11,611.6
Албан томилолтын зардал			
Сургалтын зардал		170.0	300.0
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал			
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал			
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ		1,400.0	1,500.0
Даатгал			
Түрээс		25,390.3	20,623.7
Ашиглалтын зардал			
Үндсэн хөрөнгийн этгэдлийн зардал		16,060.7	36,231.8
Харуул, хамгаалалтын зардал			
Зохицуулалтын хураамжийн зардал		2,700.0	2,700.0
Харилцаа холбоо, интернет		7,230.0	8,885.7
Шатахуун болон тээврийн зардал		14,302.0	9,937.3
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ		8,780.9	5,602.6
Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал			
Захиалгат хэвлэлийн зардал		155.7	234.0
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал		220.0	
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа		5,450.7	172.0
Бичиг хэргийн зардал		1,132.4	1,495.1
Ариун цэврийн зардал		202.7	174.2
Үл хөдлөх хөрөнгийн татвар			

Харилцагчдын сургалт судалгааны зардал		
Бусад	4,050.4	5,617.9
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН	(167,001.2)	(153,571.3)
БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН САН БАЙГУУЛАХААС ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ	451,905.2	1,034,116.2
Зээлийн эрсдэлийн зардал	222,473.8	646,334.3
Авлагын эрсдэлийн зардал		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ	229,431.4	387,781.9
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,763.8	24,673.2
ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ	227,667.6	363,108.7
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ	227,667.6	363,108.7
Орлогын татварын зардал	37,653.3	11,413.0
ЦЭВЭР АШИГ	190,014.3	351,695.7